



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

## **“ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ” ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ**

<b>I. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2018 ОНЫ 4 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ..1</b>	
I.1. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....1	1
I.2. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн.....1	1
I.3. Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулсан татвар, хураамж.....2	2
I.4. Эрдэс бүтээгдэхүүний экспорт.....2	2

## I. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2018 ОНЫ 4 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

### I.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

2018 оны эхний 4 сарын байдлаар **4.5** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **798.8 (21.5%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс **567.9 (21.0%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **295.9 (35.4%)** тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт **223.2 (14.6%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.3%**-ийг эзэлж байна.

#### Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл:

- Нүүрс	<b>14.9</b> сая тн,
- Зэсийн баяжмал	<b>445.4</b> мян.тн,
- Алт	<b>2.9</b> тн,
- Молибдений баяжмал	<b>1.8</b> мян.тн,
- Төмрийн хүдрийн баяжмал	<b>1.0</b> сая тн
- Хайлуур жоншны баяжмал	<b>21.3</b> мян.тн,
- Цайрын баяжмал	<b>30.0</b> мян.тн,
- Газрын тос	<b>2.3</b> сая бар,
- Катодын зэс	<b>4.8</b> мян.тн

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал **10.8 (2.5%)** мян.тн, төмрийн хүдрийн баяжмал **133.2 (15.0%)** мян.тн, хайлуур жоншны баяжмал **7.6 (55.5%)** мян.тн, цайрын баяжмал **1.9 (6.8%)** мян.тн-оор тус тус өссөн байна.

Харин нүүрс **1.5 (9.3%)** сая тн, алт **24.8 (0.9%)** кг, молибдены баяжмал **125.6 (6.6%)** тн, газрын тос **175.2 (7.1%)** мян.бар, катодын зэс **143.6 (2.9%)** тн-оор тус тус буурсан байна.

Салбар	Хэмжих нэгж	2017		2018*		Өөрчлөлт			
		IV	I-IV	IV	I-IV	5-3=?	5/3=?	6-4=?	6/4=?
1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>									
Нүүрс	мян.тн	4,733.2	16,431.3	3,972.7	14,905.3	-760.5	-16.1%	<b>-1,526.0</b>	<b>-9.3%</b>
Газрын тос	мян.бар	641.0	2,456.0	534.7	2,280.8	-106.3	-16.6%	<b>-175.2</b>	<b>-7.1%</b>
Зэсийн баяжмал, (м.а)	мян.тн	112.3	434.6	118.5	445.4	6.2	5.5%	10.8	2.5%
Молибдений баяжмал, (м.а)	тн	436.0	1,893.4	460.9	1,767.8	24.9	5.7%	<b>-125.6</b>	<b>-6.6%</b>
Алт	кг	856.0	2,913.1	1,017.5	2,888.3	161.5	18.9%	<b>-24.8</b>	<b>-0.9%</b>
Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	307.5	887.8	231.0	1,021.0	-76.5	-24.9%	133.2	15.0%
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	2.7	13.7	8.3	21.3	5.6	207.4%	7.6	55.5%
Цайрын баяжмал	мян.тн	7.5	28.1	6.6	30.0	-0.9	-12.0%	1.9	6.8%
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>									
Катодын зэс, 99%	тн	1,167.7	4,911.4	1,186.0	4,767.8	18.3	1.6%	<b>-143.6</b>	<b>-2.9%</b>
Металл бэлдэц	тн	1,249.2	6,826.4	3,615.4	11,622.8	2,366.2	189.4%	4,796.4	70.3%
Металл цувимал	тн	1,239.6	4,079.5	3,033.0	10,793.2	1,793.4	144.7%	6,713.7	164.6%

### I.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

2018 оны эхний 4 сарын байдлаар Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **5.3** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **807.8 (18.0%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **3.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **652.6 (20.8%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **1.4** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **304.5 (28.5%)** тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт **2.0** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **309.0 (17.9%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны 4 сард **3.9** их наяд төгрөг буюу **73.4%**, уул уурхай, олборлох аж үйлдвэр **3.4** их наяд төгрөг буюу **64.3%**-ийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

Салбар	2017		2018*			Өөрчлөлт			
	IV	I-IV	IV	I-IV	Гадаад	4-2=?	4/2=?	5-3=?	5/3=?
1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,253.0</b>	<b>4,496.9</b>	<b>1,505.4</b>	<b>5,304.6</b>	<b>3,893.7</b>	<b>252.4</b>	<b>20.1%</b>	<b>807.8</b>	<b>18.0%</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	863.0	3,134.6	1,076.2	3,787.2	3,412.8	213.2	24.7%	652.6	20.8%
Нүүрс олборлолт	344.8	1,067.6	351.8	1,372.1	1,274.4	7.1	2.1%	304.5	28.5%
Газрын тос олборлолт	74.6	308.0	91.5	334.8	334.8	16.9	22.6%	26.8	8.7%
Металлын хүдэр олборлолт	432.1	1,727.2	620.8	2,036.2	1,766.4	188.7	43.7%	309.0	17.9%
Бусад АМ олборлолт	11.5	31.8	12.1	44.1	37.2	0.5	4.5%	12.3	38.9%
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>308.9</b>	<b>1,018.2</b>	<b>336.0</b>	<b>1,116.0</b>	<b>480.9</b>	<b>27.2</b>	<b>8.8%</b>	<b>97.8</b>	<b>9.6%</b>

### 1.3. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны эхний 4 сарын улирлын байдлаар улсын төсөвт **694.8** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **11.5** тэрбум төгрөг,
- Нүүрс **255.8** тэрбум төгрөг,
- Цайр **37.7** тэрбум төгрөг,
- Зэс **352.0** тэрбум төгрөг,
- Төмөр **8.3** тэрбум төгрөг,
- Жонш **4.6** тэрбум төгрөг,
- Бусад **25.0** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **229.8** тэрбум төгрөг буюу **1.5 дахин** өссөн. Үүнээс:

- Алт **4.6** тэрбум төгрөг буюу **1.7 (66.5%)** дахин,
- Нүүрс **139.7** тэрбум төгрөг буюу **2.2** дахин,
- Цайр **15.5** тэрбум төгрөг буюу **1.7 (70.1%)** дахин,
- Зэс **72.8** тэрбум төгрөг буюу **1.3 (26.1%)** дахин,
- Төмөр **5.5** тэрбум төгрөг буюу **3.0** дахин,
- Жонш **2.8** тэрбум төгрөг буюу **2.6** дахин

Харин бусад ашигт малтмал өмнөх оны мөн үетэй харьцуулахад **11.2** тэрбум төгрөг буюу **30.9** хувиар буурсан байна.

### 1.4. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

2018 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт **3,707.3** сая ам.доллар болж 2017 оны мөн үеэс **690.0** сая ам.доллар буюу **22.9** хувиар өсчээ. Экспортын дүн импортын дүнгээс **543.4** сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарсан байна.

#### Экспорт

2018 оны эхний 4 сарын байдлаар экспортод **2,125.4** сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **11.9** хувиар өссөн байна. Үүнээс эрдэс баялгийн салбар экспортод **1,947.7** сая ам.доллар буюу **91.6** хувийг эзэлж байна.

Барааны нэр	Хэмжих нэгж	2017 IV	2018 IV	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Жонш	мян.тн	80.89	113.84	32.95	40.7%
Төмрийн хүдэр, баяжмал	сая тн	1.78	2.04	0.26	14.5%
Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн	506.50	458.58	-47.92	-9.5%
Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн	4.70	6.50	1.80	38.2%
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	39.27	41.64	2.37	6.0%
Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн	-	25.09	25.09	100%
Гянтболдын хүдэр, баяжмал	тн	108.80	81.89	-26.91	-24.7%
Молибдены хүдэр, баяжмал	мян.тн	2.11	1.88	-0.23	-11.0%
Чулуун нүүрс	сая тн	11.55	10.16	-1.40	-12.1%
Боловсруулаагүй нефть	сая бар	2.48	2.21	-0.27	-10.9%
Нефтийн бүтээгдэхүүн	мян.тн	2.47	3.85	1.39	56.3%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн	1.89	3.43	1.54	81.6%

### **Импорт**

Импортоор нийт **1,581.9** сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2017 оны мөн үеэс **464.2** сая ам.доллар буюу **41.5** хувиар тус тус өссөн байна.

---ooOoo---